

**ЗДТГ-Т 2019 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСЭЭР ӨГСӨН ЗӨВЛӨМЖИЙГ ХЭРЭГЖҮҮЛЖ АЖИЛЛАХ
ГҮЙЦЭТГЭЛ САЙЖРУУЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ**

2020.12.23

Сангийндалай

№	ХШҮДАХ-ээс өгсөн зөвлөмж	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Хүрэх түвшин	Хэрэгжилт	Хувь
1	Аливаа бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг гаргаж ирүүлэхдээ Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн, өөрийн үнэлгээг хүснэгтээр нэгтгэн, хянасан, баталгаажуулсан гарын үсэгтэйгээр тайлангийн танилцуулгын хамт холбогдох хэлтэс болон ХШҮДАХ-т заасан хугацаанд ирүүлж байх.	-Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг гаргахдаа ЗДЗХурлаар хэлэлцүүлэн, баталгаажуулах	Бодлогын баримт бичгийн хэрэгжилт бүр ЗДЗХурлаар хэлэлцүүлсэн байх	Тайлангийн чанарт ахиц өөрчлөлт гарсан байх	Сумын Засаг даргын зөвлөлийн 4 дүгээр хурлаар 2020 оны 07 сарын 07 ны өдөр Аймгийн засаг даргатай Сумын засаг дарга хамтран ажиллахаар байгуулсан гэрээ болон Сумын Засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр, Сумын 2020 оны үйл ажиллагааны үндсэн чиглэлийн 40 хувийн биелэлттэй болон тасралттай байгаа заалтуудыг мөн Санал өргөдөл гомдлын 2 дугаар улирлын тайланг тус тус хурлаар оруулж хэлэлцүүлсэн.	70
2	Ажилтнуудын сэтгэл ханамжийн санал асуулгыг тодорхой хугацаанд тогтмол хийх, ажлын байрны орчин нөхцөлийг дээшлүүлэх чиглэлээрх ажлыг төлөвлөн зохион байгуулж, ахиц өөрчлөлтийг тодорхойлсон байх.	-Санал асуулгын хуудас бэлтгэж албан хаагчдыг хамруулах -Жилд судалгаа авах тоо 2 -Төлөвлөгөө гаргах	-Хамрагдалтын хувь - 2-оос доошгүй Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	-80%-аас дээш хамрагдсан байх -80%-аас дээш	Санал асуулгын хуудас бэлтгэж ЗДТГ-ын албан хаагчдыг хамруулан сэтгэл ханамжийн судалгааг 2 удаа авсан. 1. Төрийн албан хаагчдын ажиллах орчин нөхцөл болон сургалтын хэрэгцээ шаардлагын талаарх 4 асуулт бүхий санал асуулгыг 12 албан хаагчаас авсан. 2. ЗДТГ-ын албан хаагчдын сэтгэл ханамжийн болон ажиллаж амьдрах орчин нөхцөлийн судалгааг 27 албан хаагчаас авсан. Судалгаагаар таны ажиллах орчин ажлын байрны нөхцөл, өрөө тасалгааны тохижилт хэр тав тухтай вэ? Хэмээх асуултад 28% тух муутай ус гоождог, 22% маш хүйтэн, 22% нь олуулаа суудаг.	70

				<p>Албан ажлаа хийх явцад хүндрэлтэй асуудал юу байна гэсэн асуултад 34% нь интернетийн хурд муу, гацдаг удаан, 33% нь маш хүйтэн суухад тохь муутай гэж хариулсан байна.</p> <p>Албан хаагчдын ажиллаж амьдрах орчин нөхцөлийг сайжруулах зорилгоор ЗДТГ-ын дээвэр засварын ажлыг 2020 оны 10 сарын 28 нд “Ашид бьюлдинг” ХХК-аар аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хийж гүйцэтгүүлсэн. Төсөвт өртөг 75.100.000 төгрөг.</p> <p>СӨБ: 3 асуулт бүхий санал асуулгын хуудас бэлтгэн 30 албан хаагчаас авсан. Таныг орчин нөхцөлөөр бүрэн хангаж чадаж байна уу? Гэсэн асуултад 86.6% сайн, 14.4% нь дунд гэж хариулсан байна.</p> <p>ЕБС: Албан хаагчдын ажиллаж амьдрах орчин нөхцөлийг сайжруулах зорилгоор ЕБС-ийн багш, ажилчдаас сэтгэл ханамжийн судалгааг авч нийт 57 багш хамрагдсан. Судалгаагаар 92.9% нь ажиллах орчин нөхцөл сайн гэж үнэлсэн. 7.1% нь ажиллах орчин нөхцөл дундаж гэж хариулсан.</p> <p>СДЭ: Эмнэлгийн мэргэжилтэнтэй холбоотой 8 асуулт бүхий сэтгэл ханамжийн судалгаанд эмнэлгийн 39 ажилчид хамрагдсан ба сайн гэж 80%, дунд гэж 25%, муу гэж 5% тус тус үнэлсэн байна.</p> <p>Төрийн албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах талаар 7 заалт бүхий төлөвлөгөө боловсруулан ажилласан.</p>	
--	--	--	--	--	--

					Төлөвлөгөөний хэрэгжилт 58.5 хэрэгжсэн	
3	Сумын засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр болон эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл төлөвлөгөөний хэрэгжилтийг хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4, 16 дугаар зүйлийн 16.3 дахь заалтуудыг үндэслэн иргэдийн төлөөлөгчдийн хурлаар хэлэлцүүлэн, тоон үнэлгээгээр дүгнүүлж, тайлангийн хамт ирүүлж байх.	-СЗДҮАХ, ЭЗНХҮЧ төлөвлөгөөний хэрэгжилтийг ИТХ хэлэлцүүлэн, тайлагнах	СЗДҮАХ, ЭЗНХҮЧ төлөвлөгөөний хэрэгжилтийг ИТХ хэлэлцүүлсэн байх	Тайлангийн чанарт ахиц өөрчлөлт гарсан байх	Сумын засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт хагас жилээр 82%-тай жилийн эцсээр 59.4%-тай үнэлэгдсэн. Эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл төлөвлөгөөний хэрэгжилт хагас жилээр 75.9%-тай, жилийн эцсээр 56.4%-тай үнэлэгдсэн.	30
4	Ил тод байдлын шалгуур үзүүлэлтийн хэрэгжилтэд тавих хяналтыг улирал бүр хийх, шалгуур үзүүлэлт бүрийг эзэнжүүлэх, дүн шинжилгээний ажлыг тогтмолжуулах.	- Ил тод байдлын шалгуур үзүүлэлтийн хэрэгжилтэд тавих хяналтыг улирал бүр хийх, - шалгуур үзүүлэлт бүрийг эзэнжүүлэх, дүн шинжилгээний ажлыг тогтмолжуулах.	Ил тод байдлын шалгуур үзүүлэлт тус бүрд хяналт тавин тогтмолжуулах	Хяналтын тоо	Монгол Улсын Засгийн газрын 2009 оны 143 дугаар тогтоолын хавсралтын дагуу Үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдал, Хүний нөөцийн бодлогын ил тод байдлыг СӨГХ дотоод ажил хариуцсан мэргэжилтэн, Мэдээлэл технологийн ажилтан нар хариуцан мэдээллийн ил тод байдлыг ханган ажиллаж байна. Ил тод байдлын шалгуур үзүүлэлт дүгнэх журмын 11 дүгээр хавсралтын дагуу хагас бүтэн жилээр хяналт шалгалт хийгдсэн. 2020 оны 06 сарын 19 нд хяналт хийх явцад Ил тод байдлын шалгуур үзүүлэлтэд заагдсан ажлын мэдээллийг www.dundgovi.gov.mn цахим хуудсанд 2020 оны 03 сарын 14-өөс хойш оруулаагүй зөрчлийг илрүүлж арилгуулах арга хэмжээг авсан. 2020 оны 12 сарын 18 нд жилийн эцсийн байдлаар хяналт шалгалтаар	70

					<p>үйл ажиллагааны 26 мэдээ мэдээллийг www.dundgovi.gov.mn цахим хуудсанд байршуулсан байна. Үүнд: 2019-2020 онд ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн ажлын тайлан болон видео бичлэг, СӨГ-ийн 1,2 дугаар улирлын тайлан, Улсын төсвийн хөрөнгө болон гадаадын төсөл хөтөлбөрөөр хийгдэж байгаа ажлын явц, Төрийн байгууллагуудын албан хаагчдаас үйлчилгээ авахад шаардагдах баримт бичгийн жагсаалт гэх мэт мэдээллүүдийг тухай бүр оруулж хэвшээд байна. Мөн Төсөв, санхүүгийн ил тод байдал, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны ил тод байдлын шалгуур үзүүлэлтийг Сумын засаг даргын орлогч, санхүүгийн албаны дарга нар хариуцан ажиллаж байна. 2020 онд Сургууль, Цэцэрлэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны тендрийг цахимаар зарлаж олон нийтэд ил тод нээлттэй явуулж байна. Сумын ТӨЗ-ын төсвийн гүйцэтгэлийг сар бүр Дундговь аймгийн www.dundgovi.gov.mn сайт байршуулж төсвийн ил тод байдлыг ханган ажилласан байна.</p>
--	--	--	--	--	--

5	Аймгийн сайтын Төрийн байгууллагуудын мэдээ хэсэгт байгууллагын мэдээллийг оруулж тогтмолжуулах.	-Цаг үеийн томоохон мэдээ мэдээллийг сайтад байршуулах, хөтөлгөө хийх -Хяналт тавих	-Хөтөлсөн эсэх, тоо -Хяналт хийсэн тоо	100% хөтөлгөө хийсэн байх -Улиралд 1 удаа хяналт хийсэн байх	2020 оны байдлаар www.dundgovi.gov.mn сайтад 86 удаагийн мэдээ мэдээллийг тухай бүр нэгтгэн оруулсан. Үүнээс: Орон нутгийн мэдээ хэсэг-16 мэдээ, сумын мэдээ хэсэгт-59, үйл ажиллагаа хэсэгт-26 мэдээ оруулаад байна.	100
6	Хэрэглэгчийн үнэлгээг бодитой хийлгэж, иргэдээс гарсан саналыг төлөвлөлтдөө тусган үр дүнг тухайн ондоо багтаан тухайн ондоо багтаан тайлагнаж хэвших.	Хэрэглэгчийн үнэлгээг ТББ-тай хамтран бодитой хийлгэх Хэрэглэгчийн үнэлгээг гаргах санал асуулгын хуудас бэлтгэж иргэдийг хамруулах	Хамрагдсан иргэдийн тоо	200-н иргэнээс дээш	Хэрэглэгчийн үнэлгээг “Эрдэнэдалай миний нутаг” ТББ-тай хамтран гүйцэтгүүлэхээр болсон. Ковид-19 цар тахалтай холбоотойгоор энэ заалт хэрэгжээгүй байна.	0
7	Сургууль, цэцэрлэг 1 сарын 28 нд, соёлын төв 2 сарын 3нд, эм эргэлтийн сан 1 сарын 31 нд тус тус илгээж хугацаа хоцроосон байна.	Шилэн дансны мэдээлэлд сар бүр хяналт тавих	Хяналт хийсэн тоо	6 удаагийн хяналт хийгдсэн байх	Байгууллагуудын мэдээллээ шилэн дансанд тогтмол байршуулж буй эсэхэд сар бүрийн 8 нд хяналт хийж байна. Хагас жилээс хойш 6 удаагийн хяналт хийгдсэн байна. Хяналтаар зөрчил дутагдал илрээгүй.	100
8	Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяаны байгууллагуудын шилэн дансны хэрэгжилтэд гарч байгаа гол зөрчил дутагдал нь: Мэдээллээ хугацаа хоцроож байршуулах, тайлангаа хугацаандаа илгээдэггүй, дарга, нягтлан бодогч нарын нэр холбоо барих утасны дугаарыг шинэчилдэггүй зэрэг зөрчил дутагдал байнга гарч байгаад анхаарч хуулийн хэрэгжилтийг хангах	Шилэн дансны хэрэгжилтэд гарч байгаа зөрчил дутагдлыг 2020 оны 6 сар гэхэд арилгасан байна	Зөрчил дутагдлыг арилгаж хуулийн хэрэгжилтийн хувиар	80%-аас дээш	2020 оны 06 сард шилэн дансны хэрэгжилтийг сайжруулах Аймгийн ХШҮДА-ийн газраас өгсөн зөвлөмжийн дагуу төлөвлөгөө гарган ажиллаж зөрчил дутагдлыг 3 дугаар улиралд багтаан арилгасан. Мөн байгууллагын дарга нягтлан бодогчид өөрсдийн оруулах төлөвлөгөөт мэдээллийг шилэн дансанд цаг тухай бүрт нь оруулж, Аймгийн дотоод аудитын газарт үр дүнг улирал бүр илгээж байна. Үүнд: ТЕЗ-ийн 3, ТШЗ-ийн 3, нягтлан бодогчдийн 11,	70

					Төрийн сангийн мэргэжилтний 1 Засаг даргын орлогчийн 3, Татварын улсын байцаагчийн 1 мэдээллийг хуулийн ху гацаанд нь оруулсан.	
9	Албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх чиглэлээр урт хугацааны тогтвортой хяналт, урьдчилан сэргийлэх ажил болгох талаар байгууллагын зүгээс анхаарч ажиллах.	Албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах зорилгоор урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах	Эрүүлжүүлэх хувь	Жилд 1 удаа 90%-аас дээш	<p>ЗДТГ: Албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх үзлэгт 11 сарын 10 нд хамруулахаар төлөвлөгөөнд тусган ажилласан. Тус заалт Ковид-19 цар тахал дотооддоо алдагдан хатуу хөл хорио тогтоогдсон тул тасралттай байна.</p> <p>СӨБ: Нийт 33 багш ажилчдыг аймгийн НЭ –ийн 17 төрлийн кабинетад зонхилон тохиолдох ХБӨ , 7 төрлийн хавдраас урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулж , эрүүл мэндийн эрсдэлтэй ажилтан 2, нэмэлт шинжилгээ хийлгэх 2, амбулаториор эмчлүүлэх 10, эмнэлэгт хэвтүүлэн эмчлүүлэх 4 багш ажилчдыг ангилан , төлөвлөгөө гарган эрүүлжүүлэх ажил хийгдсэн.</p> <p>В,С вирус илрүүлэх шинжилгээнд 34 / 100%/ , хеликобактери илрүүлэх шинжилгээнд 5 багш ажилчид хамрагдсан.С вирустэй 1 ажилтан гарсныг дээд шатлалд вирус тоолуулахаар явуулж эмчилгээ хийлгэсэн.</p> <p>ЕБС: Дундговь аймагт 2020 оны 09 сарын 12,17 өдрүүдэд эрүүл мэндийн багц үзлэгт 2 үе шаттай явагдсан. /18-34, 35-64 нас/ Үзлэгт 94 оролцохоос 94 багш ажилтан 100% хамрагдсан.</p> <p>Хяналтын хуудасны түүвэрлэхэд 94-17 эрүүл, 18,08% 94-77 ямар нэгэн үрэвсэлтэй буюу</p>	70

					<p>81,91% эзэлж байна.</p> <table border="1"> <thead> <tr> <th>Шинжилгээний төрөл</th> <th>Өвчлөлийн тоо</th> <th>Хувь</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>Нойр булчирхай үрэвсэл</td> <td>46</td> <td>48,13</td> </tr> <tr> <td>Бөөрний үрэвсэл</td> <td>35</td> <td>37,25</td> </tr> <tr> <td>Цөсний үрэвсэл</td> <td>32</td> <td>34,04</td> </tr> <tr> <td>Элэгний өөхлөлт</td> <td>28</td> <td>29,78</td> </tr> <tr> <td>Зүрхний цусан хангамжийн дутагдал</td> <td>17</td> <td>18,08</td> </tr> <tr> <td>Цөсний чулуу</td> <td>4</td> <td>4,25</td> </tr> <tr> <td>Цөсний ургацаг</td> <td>3</td> <td>3,19</td> </tr> </tbody> </table> <p>Соёлын төв: 2020 оны 06 сард Соёлын төвийн 6 албан хаагчийг Дундговь аймгийн Нэгдсэн эмнэлэгт нарийн мэргэжлийн үзлэг, шинжилгээнд хамруулсан. Бүгд эрүүл гарсан.</p>	Шинжилгээний төрөл	Өвчлөлийн тоо	Хувь	Нойр булчирхай үрэвсэл	46	48,13	Бөөрний үрэвсэл	35	37,25	Цөсний үрэвсэл	32	34,04	Элэгний өөхлөлт	28	29,78	Зүрхний цусан хангамжийн дутагдал	17	18,08	Цөсний чулуу	4	4,25	Цөсний ургацаг	3	3,19	
Шинжилгээний төрөл	Өвчлөлийн тоо	Хувь																												
Нойр булчирхай үрэвсэл	46	48,13																												
Бөөрний үрэвсэл	35	37,25																												
Цөсний үрэвсэл	32	34,04																												
Элэгний өөхлөлт	28	29,78																												
Зүрхний цусан хангамжийн дутагдал	17	18,08																												
Цөсний чулуу	4	4,25																												
Цөсний ургацаг	3	3,19																												
10	Нэг албан тушаал дээр тогтвортой ажиллаж буй боловсон хүчний үзүүлэлтийг судалж, дутагдалтай боловсон хүчний судалгаа гарган, хүний нөөцийг тогтвор суурьшилтай ажиллуулах талаар бодлого барин ажиллах ба хүний нөөцийг бүрдүүлэхэд онцгой анхаарч ажиллах.	Хүн тус бүрээр нь тогтвортой ажиллаж буй боловсон хүчний үзүүлэлтийг судлах	Хамрагдалтын хувь	100%	<p>Сумын хэмжээнд 2020 оны хүний нөөцийн суурь судалгаанд 194 төрийн албан хаагч хамрагдаж үүнээс 23% нь 20-с дээш жил ажилласан, 21% нь 1-3жил, 19% нь 4-7жил, 15% нь 12-15жил, 12% нь 8-11жил, үлдсэн 10% нь 16-20 жил ажилласан үзүүлэлттэй байна. Уг судалгаанаас хархад төрийн албан хаагч нар нь харьцангуй тогтвор суурьшилтай ажиллаж байна.</p> <p>ЗДТГ: ЗДТГ-ын тамгын даргын 2020 оны 01 дүгээр сарын 02 ны өдрийн А/01 тоот тушаалаар Тамгын газрын бүтэц</p>	70																								

					<p>орон тоо 25 албан хаагч байхаас Төрийн захиргааны 8 албан хаагчийн орон тоонд 3 төрийн захиргааны албан хаагч, 5 албан хаагчтай хөдөлмөрийн гэрээ байгуулан ажиллаж байна.</p> <p>ЕБС: Орос хэлний багш, хими багшийн орон тоо сул захиалгыг БСУГ-т хүргүүлсэн</p> <p>Сум дундын эмнэлэгт: батлагдсан орон тоо нь 43 албан хаагч ажиллахаас 39 албан хаагч ажиллаж байна. Дутагдалтай боловсон хүчин уламжлалт анагаах ухааны их эмч, унтуулгын эмч, багийн эмч гэсэн мэргэжлийн орон тоо дутагдаж байна. Сул орон тооны мэдээллийг сар бүрийн 25-нд аймгийн эрүүл мэндийн газрын хүний нөөцийн албанд мэдээлж байна.</p>	
11	<p>Аймгийн болон сумын дэд хөтөлбөрүүдийн хүрээнд хэрэгжилт гарсан үр дүн болон бусад холбогдох чиглэлээр өмнөх жилүүдтэй харьцуулсан судалгаа, дүгнэлт гаргаж, явц, үр дүнд хяналт тавин, чиглэл өгч ажиллах /Сумын нийгмийн бодлогын мэргэжилтэн/</p>	<p>Аймгийн болон сумын дэд хөтөлбөрүүдийн хүрээнд хэрэгжилт гарсан үр дүн болон бусад холбогдох чиглэлээр өмнөх жилүүдтэй харьцуулсан судалгаа, дүгнэлт гаргаж, явц, үр дүнд хяналт тавин, чиглэл өгч ажиллах</p>	<p>Судалгааг гарган хяналт тавих</p>	<p>Аймгийн болон сумын дэд хөтөлбөрүүдийн хэрэгжилтийн хувиар</p>	<p>ЗДТГ: Аймгийн дэд хөтөлбөрүүдийн хүрээнд жил бүр төлөвлөгөө гарган хэрэгжилтэд хяналт тавьж хагас болон бүтэн жилээр тайланг авч сумын хэмжээнд хэрэгжиж буй 15 дэд болон үндэсний хөтөлбөрийг хянан ажилласан. Нийт албан байгууллагуудын дэд хөтөлбөрүүдийн биелэлтийн хувийг өмнөх онтой харьцуулан үзэхэд 4,1%-иар буурсан үзүүлэлттэй байна.</p> <p>Цэцэрлэг: “Боловсрол” үндэсний дэд хөтөлбөрийн хүрээнд төлөвлөгөө гарган төрийн болон ТББ, АНН, иргэдтэй хамтран хэрэгжүүлж үр дүнгийн биелэлтийг хувиар тооцоход 92,5% -ийн гүйцэтгэлтэй ажилласан байна. Өмнөх онд 100%-ийн гүйцэтгэлтэй хэрэгжиж байсан уг хөтөлбөрийг энэ жилийн</p>	70

					<p>биелэлтийн хувьтай харьцуулбал 7,5%-иар буурсан байна.</p> <p>Соёлын төв: Соёл урлагийн хүрээнд үндэсний зургаан дэд хөтөлбөрийн төлөвлөгөө гарган ажилчдад ажил үүргийн дагуу хуваарилан хэрэгжүүлэн ажилласан. Биелэлтийн хувийг өмнөх онтой харьцуулж үзэхэд 2019 оны биелэлт 86,4% тай үнэлэгдсэн бол 2020 оны биелэлтийн дундаж хувь 84,1% тай үнэлэгдэж өмнөх оноос гүйцэтгэлийн хувь буурсан үзүүлэлттэй байна.</p> <p>Эмнэлэг: “Эрүүл иргэнтэй Дундговь” дэд хөтөлбөрийн хүрээнд төлөвлөгөө гарган хэрэгжүүлэн ажилласан. 2020 оны жилийн эцсээр 91,1% буюу 2019 онд 85.7 %-ийн биелэлттэй байсан. 2020 онд 5.4 хувиар өссөн үзүүлэлттэй байна.</p> <p>БД сургууль: Үндэсний болон дэд хөтөлбөрүүдийг сургалт хүмүүжлийн үйл ажиллагаандаа тогтмол хэрэгжүүлэн ажиллаж байна. Үүнээс Байгалийн ухааны дэд хөтөлбөр 90%-тай, Математик дэд хөтөлбөр 89%-тай, Үндэсний бичиг дэд хөтөлбөр 97,5%-тай, Хүүхдэд ээлтэй дотуур байр хөтөлбөр 93%-тай, Боловсрол хөгжил дэд хөтөлбөр 93%-тайгаар тус тус хэрэгжиж байна. . 2019 онд дэд хөтөлбөрийн биелэлтийн дундаж 92,5% тай хэрэгжиж байсан бол 2020 оны хэрэгжилтийн дундаж нь 86,2% тай буюу 6,3%-иар буурсан байна.</p>	
12	Эрүүл иргэнтэй Дундговь хөтөлбөрийн хүрээнд дорвитой ажил арга хэмжээ зохион	Эрүүл иргэнтэй-Дундговь хөтөлбөрийн	Төлөвлөгөөнд тусгагдсан ажлын	80%-дээш аас	“Эрүүл иргэнтэй Дундговь” дэд хөтөлбөрийн хүрээнд 2 зорилт тавин төлөвлөгөө боловсруулан ажиллаж	70

	байгуулж, үр дүнг тооцон ажиллах.	хүрээнд төлөвлөгөө боловсруулах	хэрэгжилтийн хувь		байна. Нэгдүгээр зорилтын хүрээнд Иргэн, хувь хүний идэвхтэй оролцоо, өөртөө тавих хяналтад тулгуурлан хүн амын дунд зонхилон тохиолдох элэгний В, С вирусийн халдвар, хеликобактерийн халдвар, хүний папиллом вирусийн халдвар болон бэлгийн замаар дамжих халдваруудын урьдчилан сэргийлэлт, эрт илрүүлэгийг нэмэгдүүлэх Хоёрдугаар зорилтын хүрээнд Иргэдэд эрүүл мэндийн боловсрол олгох ажлыг зохион байгуулж иргэдэд эрүүл зан үйл төлөвшүүлэх төлөвлөгөө гарган хэрэгжүүлэн ажилласан. 2020 оны жилийн эцсээр 91,1% буюу 2019 онд 85.7 %-ийн биелэлттэй байсан. 2020 онд 5.4 хувиар өссөн үзүүлэлттэй байна.	
13	Аймгаас дэвшүүлсэн зорилтын хүрээнд хийх ажлыг төлөвлөн хэрэгжилт үр дүнг хагас бүтэн жилээр тооцон тайланг холбогдох хэлтэст хугацаанд нь холбогдох хэлтэст хугацаанд нь хүргүүлэх.	Аймгаас дэвшүүлсэн зорилтын хүрээнд хийх ажлыг төлөвлөн хэрэгжилт үр дүнг хагас бүтэн жилээр тооцон тайланг холбогдох хэлтэст хугацаанд нь холбогдох хэлтэст хугацаанд нь хүргүүлэх.	Төлөвлөгөөнд тусгагдсан ажлын хэрэгжилтийн хувь	80%- дээш аас	Аймгаас дэвшүүлсэн зорилтын хүрээнд Иргэдийн ажиллаж амьдрах орчин нөхцөлийг сайжруулах жил болгон зарласантай холбогдуулан тус сумын 5 байгууллагын 2 зорилт бүхий 62 заалт төлөвлөгөөг боловсруулан хэрэгжилтийг хагас бүтэн жилээр тооцон ажиллаж байна. Хэрэгжилт жилийн эцсээр 86,24 % тай хэрэгжсэн байна.	30
14	Тайлан мэдээний чанарт анхаарч хугацаанд нь холбогдох хэлтсүүдэд хүргүүлж байх	Тайлан мэдээг чанартай гүйцэтгэж, хугацаанд нь хүргүүлж байх	Хугацаандаа хүргэгдсэн тайлангийн хувь	Тайлангийн чанарт ахиц өөрчлөлт гарсан байх	2020 оны байдлаар Хууль тогтоомж тогтоол шийдвэрийн хэрэгжилт хагас жилээр 81.5 хувьтай жилийн эцсээр 88.75%тай, хууль эрх зүйн ажлын тайлан хагас жилээр 75% жилийн	70

					эцсээр 83,1% тай, АЗДСЗД-тай хамтран ажиллах гэрээний хэрэгжилт хагас жилээр 89%, жилийн эцсээр 80.9% тай, АЗД-ын захирамжийн хэрэгжилт, СӨГ-ийн 2-р улирал 94.6% ,3-р улирал 100%, 4-р улирлын тайлан 100% биелэлттэй үнэлэгдэн ТЗУХ-т цаг хугацаанд нь хүргүүлсэн.	
15	Төрийн албан хаагчдын сахилга хариуцлагыг дээшлүүлж, ажлын байран дээр нь чадвахжуулах.	-Төрийн албан хаагчдын сахилга хариуцлагыг дээшлүүлэх төлөвлөгөө гаргах -Албан хаагчдыг чадвахжуулах дотоод сургалт зохион байгуулах	-Хэрэгжилтийн хувь -Дотоод сургалт зохион байгуулсан тоо	-100% -2 удаагийн сургалт зохион байгуулагдсан байх	Төрийн албаны сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах чиглэлээр сумын Засаг даргын “01 тоот албан даалгаварын дагуу” 32 заалт бүхий төлөвлөгөө гаргаж хэрэгжилтийг хагас бүтэн жилээр гарган дүгнүүлсэн. 70.6 хувьтай хэрэгжсэн. 10 сарын 1-ээс 6 удаагийн сонсгол мэдээлэлийн цагаар давхардсан тоогоор 200 гаруй албан хаагч хамрагдсан.	30
16	Хариутай бичиг шийдвэрлэлтэд тавих хяналтыг сайжруулж, тайлан мэдээ хоцроосон албан хаагчдад хариуцлага тооцож ажиллах	-Хариутай бичгийг цаг хугацаанд нь шийдвэрлэх, хяналт тавих -Тайлан, мэдээг хоцроосон албан хаагч нарт хариуцлага тооцож ажиллах	-Хариутай бичиг шийдвэрлэлтэд хяналт тавиж тогтмолжуулах	-Тайлангийн чанарт ахиц өөрчлөлт гарсан байх	ЗДТГ-т 2020 онд 395 бичиг ирснээс архив, албан хэрэг хөтлөлтийн ORG-AMS программд шивэлт хийгдэж, хариутай бичгийн 114 картыг эзэнжүүлж хариуг хугацаанд нь явуулсан. Хариутай бичгийг архив, албан хэрэг хөтлөлтийн программд оруулж мэдээллийг сар бүрээр гаргаж удирдлагад танилцуулж шийдвэрлэлтэд хяналт тавих ажлыг тогтмолжуулсан Мөн мэргэжилтэн бүр дээр тусгай хариутай бичгийн хавтас нээн ажиллуулж байна.	30
17	Аймгийн засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг 2.1.1-дэх заалтыг хэрэгжүүлэх ажлыг эрчимжүүлж сум бүр жижиг дунд үйлдвэр	Сум жижиг дунд үйлдвэр байгуулахад сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг	-Жижиг дунд үйлдвэр байгуулагдсан эсэх /тоо/	1	Сум хөгжүүлэх сангаас Мах, махан бүтээгдэхүүн үйлдвэрлэх чиглэлээр 1 ААНэгж, 1 иргэн 55.000.000 төгрөгний зээл авч ажлын байрны барилгыг барьж тоног төхөөрөмжөө суурилуулан бууз,	70

	байгуулахад сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг чиглүүлэх.	чиглүүлэх.			тахиааны махан бүтээгдэхүүн үйлдвэрлэж аймаг сумын дэлгүүрүүдээр борлуулж эхлээд байна.	
18	Сум хөгжүүлэх сангийн зээлийн эх үүсвэрийг эдийн засагт жижиг, дунд үйлдвэрийн эзлэх байр суурийг бэхжүүлж ажлын байрыг нэмэгдүүлэхэд чиглүүлэх, олгосон зээлийн үр дүн, хэрэгжилтийг журмын дагуу хугацаанд нь тайлагнах	-Сум хөгжүүлэх сангийн зээлийн эх үүсвэрийг эдийн засагт жижиг, дунд үйлдвэрийн эзлэх байр суурийг бэхжүүлж ажлын байрыг нэмэгдүүлэхэд чиглүүлэх, -Олгосон зээлийн үр дүн, хэрэгжилтийг журмын дагуу хугацаанд нь тайлагнах	-Нэмэгдсэн ажлын байрны тоо -Хэрэгжилийн хувь	5 80%-аас дээш	СХС-ын зээлийн үр ашгийг дээшлүүлэхэд анхаарч хяналт шалгалтыг тогтмол явуулж сумын хэмжээнд СХС-ийн зээл олгож эхэлсэн үеэс 20 ажлын байр бий болоод байна. 1, 2, 3 дугаар улирлын санхүүгийн тайланг гарган Аймгийн Санхүү төрийн сангийн хэлтэст хянуулан нэгтгэлээ. ИТХ, СХС-ын зээл олгох зөвлөл хамтран 2020 онд зээл олгосон Иргэн ААН үүдэд зээл зориулалтын дагуу хэрэгжиж байгаа эсэхэд 09 сарын 18 нд шалгалт хийлээ. Шалгалтаар зориулалтын бусаар ашиглаж байгаа зөрчил илрээгүй ба Ковид цар тахлтай холбогдуулан зарим зээлдэгчийн үйл ажиллагаа зогсонги байдалд хүрээд байна.	100
19	Малын эрүүл мэнд үзлэг, угаалга боловсруулалт, сэг зэм устгал, хороо хашааны халдваргүйтгэлийг сумын хэмжээнд оновчтой зохион байгуулах	Сумын хэмжээнд нийт малын 80% угаалгад хамруулах.	угаалгад хамруулсан малын тоо	Бүх малын 468800 толгой мал	407922 мал угаагдсан ба биелэлт 74,3%	100
		-Сэг зэм устгал, хороо бууцны халдваргүйтгэлийг сумын хэмжээнд зохион байгуулах	Халдваргүйтгэл хийгдсэн талбайн хэмжээ	34980 м2	116434 м2 талбай бүхий хороо бууц ариутгасан биелэлт 100%	
		Сумын хэмжээнд гуурын боловсруулалт зохион байгуулах	Зохион байгуулсан ажлын гүйцэтгэлийн	60% -аас дээш	17500 үхэр хамруулж биелэлт 100%	
20	Улсын болон орон нутгийн хөгжлийн сан, гадаадын төсөл хөтөлбөрөөр хийгдэж байгаа	Улсын болон орон нутгийн хөгжлийн сан, гадаадын	графикийн дагуу хийгдсэн ажлын	80%-аас дээш	Улсын болон орон нутгийн хөгжлийн сан, гадаадын төсөл хөтөлбөрөөр дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн.	100

	ажлыг графикайн дагуу эрчимжүүлэх	төсөл хөтөлбөрөөр хийгдэж байгаа ажлыг графикайн дагуу эрчимжүүлэх	гүйцэтгэлийн хувиар		Үүнд: Улсын төсвөөр 2019 оноос эхлүүлсэн 4 төсөл арга хэмжээнд нийт 4.2 тэр бум /4.200.000.000/, ОНХС-ын хөрөнгийн 30 хувийн санхүүжилтээр тус суманд Өвс тэжээлийн фонд, гүн өрмийн 5 худаг мал угаалгын 2 ш ванн нийт төсөвт өртөг нь 76.500.000 төгрөг мөн Тэнгэлэг багийн конторын барилга баригдсан. Төсөвт өртөг нь 47.329.663 төгрөг, 360 градус эргэдэг 5 ширхэг, чиглэлийн 3 камерыг шинээр суурилууллаа. Төсөвт өртөг нь 9.992.400 төгрөг, цахим худаг төсөвт өртөг нь 9.900.000 төгрөг, Агашус ХХК болон Хайдропроент ХХК нар нь хогийн зоог ландфилын аргаар булшлах ажлыг гүйцэтгэсэн. Төсөвт өртөг 44.295.000 төгрөг. ОНХСангаар 188.017.063 төгрөг болон төсөл хөтөлбөрөөр тус суманд 192,500,000 төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдсэн. Нийт 380.517.063 төгрөгний хөрөнгө оруулалт хийгдсэн.	
21	ОНХС-гийн удирдлагын системд мэдээллийг тухай бүр оруулах, ОНХС-гийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн төсөл арга хэмжээний мэдээллийг олон нийтэд мэдээлэх.	ОНХС-гийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн төсөл арга хэмжээний мэдээллийг олон нийтэд мэдээлэх	Мэдээллээр хангагдсан иргэдийн тоо	200	2020 онд ОНХС-ын хөрөнгөөр хийгдсэн төсөл арга хэмжээг ОНХС-ийн мэдээллийн системд тогтмол байршуулж 150 иргэн иргэд мэдээлэл авсан байна.	60
22	Сангийн сайдын 2019 оны 282-р тушаалаар батлагдсан журмын дагуу ОНХС-гийн эх үүсвэрээр хийгдэж байгаа бараа, ажлын санхүүжилт гаргах, баримтын бүрдлийг хангах.	ОНХС-гийн удирдлагын системд мэдээллийг тухай бүр оруулах	Удирдлагын системд Оруулсан мэдээллийн хувиар	100%	ОНХС-гийн удирдлагын системд Тогтвортой амьжиргаа төслөөс явуулсан цахим сургалтын дагуу 2018, 2019, 2020 оны мэдээллүүдийг оруулаад байна. 2020 оны ОНХС-ийн төсөл хөтөлбөр арга хэмжээний санхүүжилт оройтож мөн дутуу ирсэний улмаас хэрэгжилтийн мэдээлэл дутуу	30

					оруулсныг Аймгийн Засаг даргын орлогчийн 2020 оны 12 сарын 18 ны өдрийн 1/1492 тоот албан бичгийн дагуу мэдээллийг бүрэн оруулахаар ажиллаж байна.	
	100 хувь- 6, 70 хувь – 10, 30 хувь - 5, 0 хувь – 1					64.9

ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЯНАСАН:

ЗДТГ-ЫН ДАРГА

Г.ЭНХДЭЛГЭР

ТӨЛӨВЛӨГӨӨГ НЭГТЭГСЭН:

ЗДТГ-ЫН СӨГ, ДОТООД
АЖИЛ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН

Т.ЭРДЭНЭЗЯЯ